



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 08

Хардэн сум

Компанийн 2022 оны үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 80 дугаар зүйлийн 80.2, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7.3.12, Үндэсний аудитын газрын 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 07/561 тоот дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 01 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь 2022 онд техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлсэн, Үндэсний аудитын газраас 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэлд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгснийг тус тус харгалзан компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

3. Үндэсний аудитын газраас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмж болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооноос өгсөн зөвлөмжийг тус тус хэрэгжүүлэх талаар төлөвлөгөө боловсруулан, биелэлтийг улирал тутам Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт даалгасугай.

ДАРГА



Ж.ЖАНАРБААТАР



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 09

Хэрлэн сум

Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл  
бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.9, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, 83 дугаар зүйлийн 83.6 дахь хэсэг, “Эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх түр журам”-ын 2.4, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7.3.12 дахь заалт, гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарын 2022 онд Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хавсралтаар баталсугай.

2. Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарын 2022 оны онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг 86.5 оноогоор “Сайн” гэж дүгнэсүгэй.

3. Компанийн гүйцэтгэх захирлын онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Нарантуяа нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Ж.ЖАНАРБААТАР



“ДБЭХС” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 09 дугаар тогтоолын хавсралт



**"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛСАН 2022 ОНЫ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БҮХИЙ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

д/д	Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2022 он		Төлөвлөгөөтэй		Оноо	
			төлөв	гүйцэтгэл	зөрүү	хувь	Авбал зохих	Авсан
<b>1</b>	<b>Эдийн засгийн үзүүлэлт</b>							
1.1	Боловсруулсан ЦЭХ	сая. кВтц	223.8	242.7	18.9	108.5	5	5
1.2	Нийт түгээх ЦЭХ	сая. кВтц	262.9	278.1	15.2	105.8		
	Өөрийн түгээх ЦЭХ	сая. кВтц	191.4	210.6	19.2	110.1		
	ХАЦЭХ	сая. кВтц	71.3	67.3	(4.0)	94.4		
	Импортын ЦЭХ	сая. кВтц	0.244	0.177	(0.1)	72.5		
1.3	Түгээлт ДЭХ	мян.Гкал	316.5	326.0	9.5	103.0		
1.4	Дотоод хэрэглээний цахилгаан эрчим хүч	хувь	14.5%	13.2%	-1.25%	109.5	5	4.5
1.5	ЦЭХ-ний түгээлтийн алдагдал	хувь	7.8%	7.96%	0.16%	98.0		
1.6	Нийт орлого	сая.төг	47,651.2	52,167.5	4,516.3	109.5	5	5
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая.төг	46,332.4	50,558.1	4,225.7	109.1		
1.7	Нийт зардал	сая.төг	54,043.1	57,638.2	3,595.1	106.7	5	4
1.8	Татвар төлөхийн өмнөх ашиг	сая.төг	(6,391.8)	(5,470.7)	921.1	85.6	10	10
1.9	ААНОАТатвар	сая.төг	-	-	-	0.0		
	Цэвэр ашиг /алдагдал /	сая.төг	(6,391.8)	(5,470.7)	921.1	116.8		
1.1	БО-ын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.882	0.905	0.023	97.4	5	4
1.11	Нийт авлага	сая.төг	28,470.4	14,175.6	(14,294.8)	200.8%	5	5
1.12	Нийт өглөг	сая.төг	67,390.3	50,567.4	(16,822.9)	133.3	5	5
	Үүнээс : Богино хугацаат өглөг	сая.төг	4,900.0	8,616.1	3,716.1	56.9		
1.13	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая.төг	7,049.7	5,938.2	(1,111.6)	84.2	5	4
1.14	Түлшний хувийн зарцуулалт ЦЭХ	гр/кВтц	640.4	610.4	(30.0)	104.9	5	5
	ДЭХ	кг/Гкал	192.9	191.4	(1.5)	100.8		
1.15	Төрийн өмчийн ногдол ашгийн гүйцэтгэл, улс орон нутгийн төсөвт өр төлбөргүй байх	сая.төг	344.2	344.2		100.0	5	5
<b>2</b>	<b>Тайлангийн үр дүн</b>							
2.1	Тухайн жилийн тайлан тэнцлийн аудитын дүгнэлт, сүүлийн 2 жилийн зөвлөмжийн хэрэгжилт						6	6
2.2	Захирлын ажлын тайлан						2	2
2.3	Шийдвэрийн хэрэгжилт / ЭХЯ, ТӨБЗГ/						5	5
2.4	Худалдан авах ажиллагааны тухай хууль, шилэн дасны хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн биелэлт						5	5
<b>3</b>	<b>Үйлдвэрлэлийн осол аваарь, 1.2 дугаар зэргийн саатал</b>						15	5
	<b>ТУЗ-ӨӨС ӨГСӨН ДҮН</b>						<b>93</b>	<b>79.5</b>
4	Хэрэглэгчийн санал асуулгын дүн						3	3
5	Ажиллагсдын санал асуулгын дүн						4	4
	<b>НИЙТ ДҮН</b>						<b>100</b>	<b>86.5</b>



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 10

Хэрлэн сум

Г

Ногдол ашгийн тухай

Г

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.6, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 4.1, 4.4 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн а/774 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцлийн дүнгээр тайлант үед 5,470,702,241.26 (таван тэрбум дөрвөн зуун далан сая долоон зуун хоёр мянга хоёр зуун дөчин нэгэн төгрөг хорин зургаан мөнгө) төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт даалгасугай.

ДАРГА  Ж.ЖАНАРБААТАР

